

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2018 он 11 дүгээр сарын 23 өдрийн  
107 дугаар тогтоолын хавсралт



## “МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Эрүүл хүнс- Эрүүл Монгол хүн” зорилтын хэрэгжилтийг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалахад малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын малын гоц халдварт өвчин буурахгүй байгаа нь эдгээр өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар төрөөс онцгойлон анхаарч урт хугацааны зорилтот хөтөлбөр, арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг шаардаж байна.

Аймгийн ХАА-н үндсэн салбар нь мал аж ахуй бөгөөд орон нутгийн эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, экспортыг нэмэгдүүлэх онцгой байр суурь эзэлдэг уламжлалт салбар юм. 2018 оны байдлаар мал аж ахуйн үйлдвэрлэлд 7407 малчин өрхийн 15,6 мянган хөдөлмөрийн насны малчин ажиллаж байна.

2018 оны эхний хагас жилээр аймгийн мал сүрэг 3844,6 мянган толгойд хүрч, хонин толгойд шилжүүлснээр 5741,5 мянган малтай болж, нийт малын 0,7 хувийг тэмээ, 3,7 хувийг адуу, 5,6 хувийг үхэр, 38,6 хувийг хонь, 51,4 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Малын гоц халдварт өвчин шинээр болон дахин сэргэж байгаатай уялдан мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх нөхцөл хязгаарлагдмал байдлыг үүсгэсэн зэрэг шийдвэрлэвэл зохих бэрхшээлтэй олон асуудал байна.

Аймгийн хэмжээнд мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлого шийдвэрийг мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлогч улс орнуудаас тавьдаг шаардлагад нийцүүлэх мал эмнэлгийн салбарын тогтвортой хөгжлийг хангах арга хэмжээг цогц, оновчтой болгох нь “Малын эрүүл мэнд” дэд хөтөлбөр /цаашид дэд хөтөлбөр гэх/ - ийг боловсруулах үндэслэл болж байна.

## **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа**

### **2.1. Хөтөлбөрийн зорилго**

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан, эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй тайван байдлаа дотоод болон гадаад орчинд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд оршино.

### **2.2. Хөтөлбөрийн зорилт.**

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна:

2.2.1. Мал аж ахуйн салбарт шинээр батлагдаж гарсан мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах хуулийн хэрэгжилт, түүнийг дагаж мөрдөх дүрэм журам заавруудыг нийтэд мөрдүүлж хэвшүүлэх.

2.2.2. Мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан баталгаажуулах.

2.2.3. Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар хяналтад авах

2.2.4. Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох.

2.2.5. Мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

2.2.6. Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах.

### **2.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаа:**

Хөтөлбөрийг 2019-2021 онд хэрэгжүүлнэ.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

3.1. Хөтөлбөрийн 2.2.1 дэх зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:



3.1.1. Аймгийн мал эмнэлгийн газар, сумдын мал эмнэлгийн тасгийг байгуулж, боловсон хүчнийг томилох, ажлын байр, ажиллах нөхцөл, материаллаг баазыг бэхжүүлэх.

3.1.2. Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хүрээнд хийгдэх мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлж, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, мал эмнэлгийн ерөнхий газраас батлан гаргасан дүрэм журам заавруудыг мөрдөж ажиллах.

3.1.3. Мал амьтны гоц халдварт, зооноз халдварт, бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх 2019-2021 онд хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөө боловсруулж, ИТХ-н хурлаар хэлэлцүүлж батлуулан хэрэгжүүлэх.

3.1.4. Малын шилжилт хөдөлгөөн мал аж ахуйн гаралтай бараа бүтээгдэхүүнд тавих дотоод хяналтын стандарт журмыг нэвтрүүлэх

3.1.5. Сумдын мал эмнэлгийн нэгжүүдэд үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх, хяналт тавих.

### **3.2. Хөтөлбөрийн 2.2.2 дахь зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

3.2.1. Монгол улсын мал эмнэлгийн салбарын мэдээллийн нэгдсэн цахим сүлжээнд холбогдож, мэдээллийн бааз байгуулах.

3.2.2. Аймгийн мал эмнэлгийн лабораторийн барилгад их засвар хийж, тоног төхөөрөмжийн хүчин чадал, эмч мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар, оношилгоо шинжилгээний чадавхыг нэмэгдүүлэх.

3.2.3. Баруун бүсийн мал эмнэлгийн лабораторийг Ховд аймагт байгуулж, бүс нутгийн хэмжээнд оношилгоо, зорилтот тандах шинжилгээ, судалгааны ажлыг үе шаттай зохион байгуулж үр дүнг гаргах, гоц халдварт халдварт зооноз өвчнүүдийн халдварлалт тархалт, эрүүлжилтийн түвшнийг тогтоох.

3.2.4. Шүлхий, бог малын мялзан зэрэг гоц халдварт өвчин, бруцеллёз, ям сүрьеэ, лейкоз, адууны Халдвар цус багсах өвчин /ХЦБӨ/ зэрэг зооноз халдварт өвчнөөс аймгийн мал сүрэг эрүүл эсэхийн баталгаа гаргах.

### **3.3. Хөтөлбөрийн 2.2.3 дахь зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

3.3.1. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг тархвар зүй, лабораторийн тандах судалгаанд үндэслэн оновчтой төлөвлөн хэрэгжүүлэхийн

зэрэгцээ үр дүнг лабораторийн шинжилгээгээр тогтоон үнэлж, дүн шинжилгээ хийж байх.

3.3.2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний эдийн засгийн үр ашгийн тооцоо хийж, тэмцэх, сэргийлэх арга технологид ахиц өөрчлөлт, дэвшил гаргах.

3.3.3. Мал эмнэлгийн эм био бэлдмэлийн хадгалалт, тээвэрлэлт, хүргэлтийн ложистик сүлжээ нэвтрүүлж, аймгийн мал эмнэлгийн газарт хөргүүртэй автомашин, сумын мал эмнэлгийн тасаг нэгжүүдийг зориулалтын хөргүүрээр хангах.

3.3.4. Жил бүр гоц халдварт, халдварт өвчний эрсдэлийн үнэлгээ хийж, тэдгээртэй тэмцэх сэргийлэх бэлэн байдлын аюулгүйн нөөц бүрдүүлэх.

#### **3.4. Хөтөлбөрийн 2.2.4 дэх зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

3.4.1. ОХУ болон БНХАУ-тай мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн экспортлох гэрээ хэлэлцээр байгуулан хамтарч ажиллах төрийн бодлогыг дэмжиж ажиллах.

3.4.2. Аймгийн мал нядлах, мах боловсруулах үйлдвэрүүдийн эрүүл ахуй ариун цэвэр хорио цээрийн шаардлагыг өндөржүүлэх, хамтарч ажиллах.

3.4.3. Мал амьтны дотоодын шилжилт хөдөлгөөний хяналтыг чангатгаж, цахим бүртгэл хяналтын сүлжээ нэвтрүүлэх.

3.4.4. Дарви сумын Дундын овоо, Мянгад сумын Ховд голын гүүр, Эрдэнэбүрэн сумын Хашаатын хөтөл, Булган сумын Ярантын боомтод мал эмнэлгийн хяналтын цэг байгуулж, хорио цээрийн үйл ажиллагаа, шилжилт хөдөлгөөнийг хянах, материаллаг бааз, ажиллах хүч, бэлэн байдлыг хангах.

3.4.5. Зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөн, эрүүл мэндийн байдалд жил бүр ажиглалт, тандалт судалгаа дүн шинжилгээ хийж байх.

#### **3.5. Хөтөлбөрийн 2.2.5 дахь заалтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

3.5.1. Аймгийн малын эмч нарын мэргэжлийн зөвлөл байгуулж, үйл ажиллагааны дүрэм, журмыг батлан хэрэгжүүлэх.

3.5.2. Аймгийн мал эмнэлгийн газар, лаборатори, сумдын мал эмнэлгийн тасаг, нэгжүүдийн эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.

3.5.3. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн хүний нөөцийн төлөвлөгөө, бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

3.5.4. Аймаг, сум орон нутагт ажиллаж байгаа малын эмч нарын цалин, нэмэгдэл урамшуулал, нийгмийн баталгааг хангаж, тогтвортой үр бүтээлтэй ажиллах нөхцөл бололцоог хангах асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэх.

### **3.6. Хөтөлбөрийн 2.2.6 дахь зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

3.6.1. Мал амьтны эрүүл мэндийн даатгалын тогтолцоог орон нутгийн хэмжээнд нэвтрүүлж ажиллах.

3.6.2. Малчдыг малын эрүүл мэнд, хууль эрх зүй, эмийн зохистой хэрэглээний чиглэлийн мэдээллээр хангах үе шаттай сургалтыг зохион байгуулж, мал эмнэлгийн үйлчилгээнд тавих хэрэглэгчийн хяналтыг сайжруулж, хариуцлагыг өндөржүүлэх.

3.6.3. Мал амьтны өвчлөл, мал эмнэлгийн үйлчилгээний ач холбогдлыг олон нийтэд таниулсан сургалт, сурталчилгаа зохион байгуулах,

3.6.4. Малчин өрх бүрийг малын эрүүл мэндийн дэвтэртэй болгох ажлыг зохион байгуулж, хөтлөлт, хяналтын тогтолцоог бий болгох.

### **Дөрөв. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт**

#### **4.1. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт**

4.1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ 2019, 2020, 2021 оны жилийн эцсийн үзүүлэлтийг суурь болгон явц хүрэх үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлэн дүгнэх.



№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	
			Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
1	Зорилт 1. Мал аж ахуйн салбарт шинээр батлагдаж гарсан мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах хуулийн хэрэгжилт, түүнийг дагаж мөрдөх дүрэм журам заавруудыг нийтэд мөрдүүлж хэвшүүлэх.	Хууль хэрэгжсэнээр мал эмнэлгийн шинэчлэгдэн боловсруулж гарсан дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах	2018 2019	22 журам 70 заавар	2021	92 заавар журам, дүрэм бүрэн батлагдаж үйл ажиллагаандаа мөрдүүлсэн байна.
2	Зорилт 2. Мал, амьтны гоц халдварт болон шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан орон нутгийн хэмжээнд баталгаажуулах.	Халдварт өвчингүй статустай газар нутгийн хэмжээг тогтоох	2019	Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах	2021	Лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэсэн гоц халдварт болон халдварт өвчингүй тайван байдалд шилжсэн
3	Зорилт 3. Мал, амьтны гоц халдварт, халдваргүй зооноз, паразиттах өвчин, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвал зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар сум бүс нутгаар нь хяналтад авах	Гоц халдварт шүлхий, бог малын мялзан, галзуу, боом өвчинд дархлаажуулалт хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал сүргийг хамруулах	2019	Боом, галзуу, зэрэг халдварт өвчнүүдийн голомт бүхий сумдыг хамруулна	2021	Халдварт болон халдваргүй паразиттах өвчний гаралт багассан байна
4	Зорилт 4. Мал амьтны шилжилт хөдөлгөөнд зохицуулалт хийж малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж экспорттой холбогдсон чанар аюулгүй байдлыг хангуулсан байх.	Шилжилт хөдөлгөөний хяналт сайжирч, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлын баталгаа хангагдах	2019	Мал эмнэлэг ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээг шинэчлэх, мах, махан бүтээгдэхүүнийг боловсруулж үйлдвэрлэх	2021	Малын шилжилт хөдөлгөөний асуудалд ахиц гарсан, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн байна

5	Зорилт 5. Мал эмнэлгийн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, ажиллах боловсон хүчний хангалтыг сайжруулж, малын эмчийн ур чадварыг дээшлүүлэх	Төр хувийн хэвшилтэй хамтарч ажиллах малын эмчийг мэргэшүүлэх, туршлага судлуулах, сургалтад хамруулах	2019	Малын эмчийг бэлтгэх, лабораторийн шинжлэгч эмч нарыг мэргэшүүлэх	2021	Мал эмнэлгийн үйлчилгээ, малын эмч нарын ажиллах ур чадвар сайжирсан ажиллах хүчээр хангагдсан байна.
6	Зорилт 6. Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах	Малын эрүүл мэндийн даатгалын тогтолцоог эхлүүлэх, малчдад зориулсан мал эмнэлгийн үйлчилгээний мэдлэгийг дээшлүүлэн, олон нийтэд хүргэх сургалт сурталчилгаа хийх	2019	Мал эмнэлгийн тогтолцоог шинээр байгуулах, мал амьтны өвчлөлийг бууруулах мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	2021	Малын эрүүл мэндийн даатгалын тогтолцоо бий болж, малын эрүүл мэндийн асуудал сайжирч, өвчний гаралт буурсан байна.

### Тав. Хөтөлбөрийн санхүүжилт, шаардагдах хөрөнгийн эх үүсвэр

5.1. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.1.1. Улсын болон орон нутгийн төсөв.

5.1.2. Гоц халдварт өвчин дэгдсэн онцгой байдлын үед улсын болон орон нутгийн төсвөөс.

5.1.3. Орон нутгийн хөгжлийн сан.

5.1.4. Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

### 5.2. Малын эрүүл мэнд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө

№	Хийгдэх ажлын чиглэл	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага		Төсөв /Сая, төгрөг/	Эх үүсвэр
			Хариуцагч	Хамтран хэрэгжүүлэгч		
Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах хуулийн хэрэгжилт, түүнийг дагаж мөрдөх дүрэм журам заавруудыг нийтэд мөрдүүлж хэвшүүлэх.						
1	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг таниулан сурталчлах, мал	2019	МЭГ	Аймгийн ЗДТГ Сумын	3,0	Орон нутгийн төсвөөс
		2020			2,5	Орон нутгийн



	эмнэлгийн салбарын мэргэжилтэн, албан хаагчийн ажлын үүрэг, хариуцлага эрх зүйн хэм хэмжээ журам зааврыг мөрдүүлэх хяналт, зөвлөмж чиглэлийг хэрэгжүүлэх (хуулийн 30 дугаар зүйлийн 30.12 дахь заалт)	2021		ЗДТГ Мал эмнэлгийн тасаг	1,5	төсвөөс Байгууллагын зардлаас
2	Гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж болох өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх / боом, мялзан, шүлхий / лабораторийн шинжилгээгээр бус нутгийн халдварт өвчингүй статустай газар нутгийн хэмжээг өргөсгөх	2019 /17 сумын 10,000 толгой малд түүвэр/	МЭГ	УМЭАЦТЛ Мал эмнэлгийн газар Сумын МЭ тасаг Мал эмнэлгийн ерөнхий газар	Боом, бруцеллёз 20000000	Орон нутгийн төсвөөс
		2020 /эрсдэлтэй сумдад/			Шүлхий, мялзан	Улсын төсвөөс
		2021 /эрсдэлтэй малд/			Боом, бруцеллёз 10000000	Орон нутгийн төсвөөс
					Шүлхий мялзан	Улсын төсвөөс
					Боом, бруцеллёз 10000000	Орон нутгийн төсвөөс
					Шүлхий мялзан	Улсын төсвөөс
3	Гоц халдварт шүлхий, бог малын мялзангийн дархлаажуулалтыг лабораторийн болон тархвар зүйн судалгааг үндэслэн эрсдэлтэй сумдын тоог багасгах	2019 /шатахуун /	МЭГ	Мал эмнэлгийн ерөнхий газар УМЭАЦТЛ МЭГ Сумын МЭ тасаг МЭҮҮН	1000000 /тел мал/	Орон нутгийн төсвөөс
		2020			1000000	Байгууллагын зардлаас
		2021			1000000	Байгууллагын зардлаас
4	Зоонозын халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор бэтэг, галзуу өвчний вакцин, туулгалт хийх	2019-2020 2021	МЭГ	Зооноз өвчин судлалын төв, Сумдын ЗДТГ, МЭТ, МЭҮН,	20000000 /вакцин туулгалт, гэрчилгээ/	Орон нутгийн төсвөөс
5	Малын шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах, аймгийн хэмжээнд шинээр 3-4 мал эмнэлгийн хяналтын пост ажиллуулах, (улирлын	2019	МЭГ	Аймгийн ЗДТГ Мал эмнэлгийн газар МЭЭГ	5,0	Орон нутгийн төсвөөс
		2020			3,0	Орон нутгийн төсвөөс
		2021			2,0	Орон нутгийн төсвөөс



	чанартай)			МХЕГ ОБГ		
6	Малчин өрхийн малын эрүүл мэндийн дэвтрийг шинэчлэн боловсруулж, малчин, мал бүхий иргэдэд бүрэн олгох	2019	МЭГ	Сумдын МЭТ, МЭҮН-үүд	30,0 /нэг бүрийн үнэ 3000, эх бэлтгэх/	Байгууллагын зардлаас
7	Лабораторийн эм, урвалж оношлуурын түргэн тестийн нөөц бүрдүүлэх	2019 /боом, галзуу, мялзан, шүлхий/	МЭГ	Аймгийн ЗДТГ МЭЕГ УМЭАЦТЛ	11.2	Төсөл хөтөлбөр
		2020			5.6	Орон нутгийн төсвөөс
		2021			5.6	Орон нутгийн төсвөөс

2. Мал эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлэх, боловсон хүчний хангамж, хүрэлцээг сайжруулах, дадлагажуулах, мэргэшүүлэх, сургалт үйлдвэрийн холбоог бэхжүүлэх

1	Сумдын МЭТасагт зөөврийн хашаа зөөврийн угаалгын ваннаар хангана.	2019	МЭГ	МЭЕГ Аймгийн ЗДТГ Сумын ЗДТГ	22,5 /9 суманд зөөврийн хашаа олгох/	Төсөл хөтөлбөр
					Мал угаалгын ванн 156,0	Улсын төсвөөс
2	Мал эмнэлгийн газарт ариутгал халдваргүйжүүлэлтийн хүчин чадал өндөр ариутгалын дук машин авах вакцины хөргүүр машин	2019- 2020	МЭГ	Аймгийн ЗДТГ МЭЕГ	30,0	Орон нутгийн төсвөөс Улсын төсвөөс
					30,0	
3	Мал эмнэлгийн байгууллагын гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар эмч нарыг гадаад оронд сургах туршлага судлуулах, мэргэшүүлэхэд жилд 1-с доошгүй мэргэжилтэнг хамруулах	2019	МЭГ	МЭЕГ Аймгийн ЗДТГ Сумын ЗДТГ	3,5	Орон нутгийн төсвөөс
		2020			3,5	Орон нутгийн Төсвөөс
		2021			3,5	Орон нутгийн төсвөөс
4	Сүү, мах, махан бүтээгдэхүүнд антибиотикийн үлдэгдэл илрүүлэх багаж төхөөрөмж / perim test/	2019	МЭГ	Аймгийн ЗДТГ	2.4	Орон нутгийн төсвөөс
		2020			1.0	Орон
		2021			1.0	Орон нутгийн

						төсвөөс
5	Мал эмнэлгийн ариун цэврийн лабораторийн барилгын их засвар	2019	МЭГ	МЭЕГ ЗДТГ	274,6	Улсын болон орон нутгийн төсвөөс

5.2.2. Малын эрүүл мэндийн дэд хөтөлбөрийн хүрээнд 2019-2021 онуудад хийж хэрэгжүүлэх зардлын төлөвлөгөө.

Дд	Он	Зардлын эх үүсвэр	Дүн /төгрөгөөр/
1	2019	Улсын төсвөөс	186000000
		Орон нутгийн төсвөөс	96100000
		Төсөл хөтөлбөрөөс	22500000
		Байгууллагын зардлаас	30000000
		Лабораторийн их засвар	274562156
		<b>2019 оны дүн</b>	<b>609162156</b>
2	2020	Орон нутгийн төсвөөс	25600000
		Байгууллагын зардлаас	1000000
		<b>2020 оны нийт дүн</b>	<b>26600000</b>
3	2021	Орон нутгийн төсвөөс	22100000
		Байгууллагын зардлаас	2500000
		<b>2021 оны нийт дүн</b>	<b>24600000</b>
<b>Нийт дүн</b>			<b>660362156</b>

### **Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг сумын мал эмнэлгийн тасаг жил бүр гаргаж, мал эмнэлгийн даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн жил бүрийн 11 дүгээр сард багтаан аймгийн Засаг даргад танилцуулна.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хяналт-шинжилгээ, үнэлгээг бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналтын газар, мэргэжлийн байгууллагууд, мал бүхий иргэдтэй хамтран гүйцэтгэж дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг, Засаг даргын тамгын газрын хяналт- шинжилгээ үнэлгээний хэлтэс үнэлнэ.

6.3. Явцын хяналт- шинжилгээ, үнэлгээний дүгнэлтийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

### **Долоо. Хөтөлбөрийн, удирдлага зохион байгуулалт, хэрэгжилт**

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг бүх шатны Засаг дарга, мал эмнэлгийн байгууллага хангаж хэрэгжүүлж ажиллана.

7.2.Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймгийн Засаг даргын зөвлөл, иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар баталж, үр дүнг жил бүр тооцно.

--oOo--